

ХУВЬЦААНЫ ЭРХ БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

20.. оны ... дугаар

Улаанбаатар хот

сарын ...-ны өдөр

Нэг талаас: Монгол улсын иргэн, “.....” ХХК-ийн хувьцаа эзэмшигч /цаашид “А тал” гэх/,

нөгөө талаас: Монгол улсын иргэн, “.....” ХХК-ийн хувьцаа эзэмшигч /цаашид “Б тал” гэх, хамтад нь “Талууд” гэх/ нар доорх нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү ”Хувьцааны эрх буцаан шилжүүлэх тухай гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г байгуулав.

Нэг. Гэрээний нөхцөл

1.1 Энэхүү гэрээгээр “Б тал” нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу өөрийн эзэмшлийн нийт хувьцааг түүнд ноогдох хөрөнгө болон удирдлагын эрхийн хамтаар “А тал”-д бүрэн шилжүүлэхтэй холбогдон талуудын хооронд үүсэх эрх зүйн харилцааг зохицуулна.

1.2

1.3 “А тал” нь “Хөрөнгө оруулалт хийж, барилга барих тухай гэрээ”-гээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд “Б тал” нь өөрийн эзэмшлийн нийт хувьцааг “А тал”-д буцаан шилжүүлэхээр талууд харилцан тохиролцсон бөгөөд “Б тал” нь энэхүү нөхцөлийг бүрэн хүлээн зөвшөөрч буй болно.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1 Энэхүү гэрээ нь 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсний дагуу гэрээний 3.1-д заасан хувьцаа “А тал”-ын эзэмшилд бүрэн шилжиж, энэ тухай улсын бүртгэлд бүртгэгдсэнээр дуусгавар болно.

Гурав. Хувьцаа

3.1 “Б тал”-аас “А тал”-ын эзэмшилд буцаан шилжүүлэх хувьцаа нь “.....” ХХК /УБД:, РД:/-ийн нийт хувьцааны хувьтай тэнцэх хэмжээний нэг бүрийн үнэ нь төгрөг байх, нийт төгрөгийн үнэ бүхий ширхэг энгийн хувьцаа байна.

3.2 Талууд гэрээний 3.1-д заасан хувьцааг “Б тал”-аас “А тал”-ын эзэмшилд буцаан шилжүүлэх үед “Бэлэглэлийн гэрээ”-г байгуулах ба “Б тал” нь хувьцааг “А тал”-д буцаан шилжүүлэхтэй холбогдуулан аливаа төлбөр төлөх шаардлага гаргахгүй болохыг үүгээр баталгаажуулж байна.

Дөрөв. “А тал”-ын эрх, үүрэг

4.1 “А тал” нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

4.1.1 “Б тал”-аас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийг шаардах;

4.1.2 “А тал” нь “Барилга барих тухай гэрээ”-гээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд гэрээний 3.1-т заасан хувьцааг буцаан шилжүүлэхийг “Б тал”-аас шаардах;



- 4.1.3 Хувьцааны эрхийг өөрт шилжүүлэн авсан тухай улсын бүртгэлд бүртгүүлэн баталгаажуулахтай холбогдон “Б тал”-аас бүрдүүлбэл зохих бичиг баримтыг бүрэн гаргаж өгөхийг шаардах
- 4.1.4 “Б тал” нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүдэн өөрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.
- 4.2 “А тал” нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 4.2.1 “Барилга барих тухай гэрээ”-нд заасны дагуу барилга болон барилгын гадна шугам, сүлжээний зураг төслийг гаргаж, улсын экспертизээр баталгаажуулах, эрх бүхий байгууллагуудаас техникийн нөхцөлүүд авах, эзэмшил газрын зориулалтыг орон сууцны барилга барих зориулалттай болгон өөрчлөх, барилга угсралтын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлүүдийг авч, барилга барих бэлтгэл ажлыг бүрэн хангах үүргээ бүрэн биелүүлэх;
 - 4.2.2 “Барилга барих тухай гэрээ”-ний хэрэгжилтийн талаар “Б тал”-д шаардлагатай мэдээллийг өгөх үүрэгтэй.

Тав. “Б тал”-ын эрх, үүрэг

- 5.1 “Б тал” нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 5.1.1 “А тал”-аас гэрээний 4.2.1-д заасан үүргээ бүрэн биелүүлэхийг шаардах;
 - 5.1.2 “Барилга барих тухай гэрээ”-ний хэрэгжилтийн талаар мэдээлэл авах;
 - 5.1.3 “А тал” нь гэрээний 4.2.1-д заасан үүргийг биелүүлээгүй үед хувьцааг шилжүүлэхээс татгалзах эрхтэй.
- 5.2 “Б тал” нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 5.2.1 “А тал” нь “Барилга барих тухай гэрээ”-гээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн нөхцөлд гэрээний 3.1-т заасан хувьцааг “А тал”-ын эзэмшилд буцаан шилжүүлэх;
 - 5.2.2 Хувьцааны эрхийг “А тал”-д шилжүүлсэн тухай улсын бүртгэлд бүртгүүлэн баталгаажуулахтай холбогдон өөрийн зүгээс бүрдүүлбэл зохих бичиг баримтыг “А тал”-д бүрэн гаргаж өгөх үүрэгтэй.
 - 5.2.3 “Б тал” нь “А тал”-д гэрээний 3.1-д заасан хувьцааг буцаан шилжүүлэхдээ “А тал”-тай “Бэлэглэлийн гэрээ” байгуулах үүрэгтэй ба уг гэрээний дагуу “А тал”-аас аливаа төлбөр төлөхийг шаардах, гэрээ байгуулагдсанаас хойш хувьцааг буцаан авахаар шаардлага гаргах эрхгүй.

Үргэлжлэл бий /4х/